



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/565

Зуунмод

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 “а”, “б”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.5, 3 дугаар зүйлийн 3.2, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын шуурхай хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдол нэмэгдэж Монгол Кувейтын төвд нэмэлтээр эмнэлэг дэлгэсэнтэй холбогдуулан хэвтэн эмчлүүлж байгаа иргэдийн түрээсийн төлбөрийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 17,430,000 (арван долоон сая дөрвөн зуун гучин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР